

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Даланзадгад сумын хорин тав дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2026/060/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533552 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaa.ja@audit.gov.mn
Аудитор: Н.Хулан
Утас: 70533552 Цахим хаяг: Khulann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ДАЛАНЗАДГАД СУМЫН ХОРИН ТАВ
ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.БАТЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Даланзадгад сумын хорин тав дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс 90,927.2 мянган төгрөг олгохдоо нэмэгдэл хөлс олгох хуудас бүрэн хөтлөөгүй, байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй;
- Хүүхдийн хоолны нормыг 1,085.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
- Хүнсний тайланд тусгасан 70,384.6 мянган төгрөгийн орлогын баримт, зарлагын 20,542.6 мянган төгрөгийн баримт тус тус дутуу;
- Анхан шатны баримтаар нотлогдохгүй 450.0 мянган төгрөгийн албан томилот олгосон.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хэвсрэлт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын гуравдугаар бүлгийн 1 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2024 оны "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 237 дугаар тогтоолоор баталсан норм, нормативтай

4626050078

Бичиг хэргийн хэлтэс

нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

2025-2026 оны хичээлийн жилд шинэчилсэн сургалтын хөтөлбөр болон Монтессори, Стем, Таксонамын сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 120,204.1 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 147,257.1 мянган төгрөгийн "Нутгийн дэм", 39,137.4 мянган төгрөгийн хүүхдийн хоолны нэмэгдэл, 16,348.4 мянган төгрөгийн зуны цэцэрлэгийн зардлын санхүүжилт олгосон байна.

Бусад асуудал хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 90 хувьтай дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

	/Төгрөгөөр/	
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>438,168,321.24</u>	<u>224,354,182.24</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	223,602,764.24	37,411,404.24
Банканд байгаа бэлэн мөнгө	223,602,764.24	37,411,404.24
Төгрөг	223,602,764.24	37,411,404.24
Төрийн сангийн харилцах	223,602,764.24	37,411,404.24
БАРАА МАТЕРИАЛ	214,565,557.00	186,942,778.00
Түүхий эд материал	-	300,000.00
Эм боох материал	-	300,000.00
Хангамжийн материал	214,565,557.00	186,642,778.00
Хүнсний материал	7,408,700.00	1,734,228.00
Бусад хангамжийн материал	207,156,857.00	184,908,550.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,916,596,079.01</u>	<u>1,886,010,574.17</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,916,596,079.01	1,886,010,574.17
Биет хөрөнгө	1,781,948,579.01	1,751,408,074.17
Барилга, байгууламж, орон сууц	1,923,913,581.93	1,923,913,581.93
Хуримтлагдсан элэгдэл	(344,228,142.79)	(376,293,369.19)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,069,150.60	173,035,402.60
Хуримтлагдсан элэгдэл	(45,917,350.60)	(81,037,605.72)
Тавилга, аж ахуйн эд хогшил	128,056,449.00	170,637,449.00
Хуримтлагдсан элэгдэл	(58,402,699.90)	(75,586,288.42)
Бусад үндсэн хөрөнгө	87,438,931.00	87,438,931.00
Хуримтлагдсан элэгдэл	(58,981,340.23)	(70,700,027.03)
Биет бус хөрөнгө	134,647,500.00	134,602,500.00
Програм хангамж	450,000.00	450,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(377,500.00)	(422,500.00)
Бусад биет бус хөрөнгө	134,575,000.00	134,575,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,354,764,400.25</u>	<u>2,110,364,756.41</u>
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,354,764,400.25</u>	<u>2,110,364,756.41</u>
Засгийн газрын хувь оролцоо	2,354,764,400.25	2,110,364,756.41
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	134,575,000.00	134,575,000.00
Хуримтлагдсан үр дүн	2,220,189,400.25	1,975,789,756.41
Өмнөх үеийн үр дүн	2,220,189,400.25	2,220,189,400.25
Тайлант үеийн үр дүн	-	(244,399,643.84)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,354,764,400.25</u>	<u>2,110,364,756.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,592,437,695.71	1,486,789,840.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	394,026,495.71	390,384,240.00
Нийтлэг татварын бус орлого	394,026,495.71	390,384,240.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	286,406,262.11	323,157,088.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	278,951,262.11	323,157,088.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,455,000.00	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	44,608,833.60	61,346,252.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	63,011,400.00	5,880,900.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,198,411,200.00	1,096,405,600.00
Улсын төвлөрсөн төсвөөс	1,112,982,100.00	995,528,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,112,982,100.00	995,528,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,429,100.00	100,877,600.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,429,100.00	100,877,600.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,414,114,053.21	1,731,189,483.84
УРСГАЛ ЗАРДАЛ	1,414,114,053.21	1,731,189,483.84
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,351,082,501.49	1,700,082,398.78
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	907,704,890.50	1,179,709,263.71
Үндсэн цалин	521,021,317.67	713,699,390.13
Нэмэгдэл	360,120,517.00	375,553,112.34
Унаа хоолны хөнгөлөлт	-	29,299,186.00
Урамшуулал	26,563,055.83	61,157,575.24
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,652,236.81	138,121,580.29
Тэтгэврийн даатгал	77,813,497.27	93,085,022.89
Тэтгэмжийн даатгал	9,469,181.68	11,487,668.75
ҮОМШӨ-ний даатгал	4,109,037.90	5,557,788.97
Ажилгүйдлийн даатгал	4,020,732.94	5,529,638.94
Эрүүл мэндийн даатгал	18,239,787.02	22,461,460.74
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,902,757.28	67,033,828.94
Гэрэл, цахилгаан	18,366,816.16	19,205,784.98
Түлш, халаалт	29,997,281.12	39,944,643.96
Цэвэр, бохир ус	11,538,660.00	7,883,400.00

Хангамж, бараа материалын зардал	20,343,270.00	42,492,707.00
Бичиг хэрэг	4,100,630.00	-
Тээвэр, шатахуун	3,200,000.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,549,160.00	-
Бараа материал акталсны зардал	5,493,480.00	42,492,707.00
Нормативт зардал	135,756,070.00	140,167,082.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	411,220.00	-
Хоол, хүнс	135,344,850.00	140,167,082.00
Эд хогшил, урсгал засварын зардал	14,837,500.00	11,000,000.00
Урсгал засвар	14,837,500.00	11,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,741,300.00	3,792,230.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,741,300.00	3,792,230.00
Бараа үйлчилгээний бусад зардал	96,144,476.90	117,765,706.84
Бараа үйлчилгээний бусад зардал	12,100,700.00	18,941,250.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,691,700.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,043,776.90	96,132,756.84
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,031,551.72	31,107,085.06
Бусад урсгал шилжүүлэг	52,105,209.00	8,263,314.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	52,105,209.00	8,263,314.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,926,342.72	22,843,771.06
Төвлөрүүлэх шилжүүлэг	10,926,342.72	22,843,771.06
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>178,323,642.50</u>	<u>(244,399,643.84)</u>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,245,453.52	-
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,245,453.52	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,245,453.52)	-
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>176,078,188.98</u>	<u>(244,399,643.84)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,477,362,462.11	1,419,562,688.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	278,951,262.11	323,157,088.00
Нийтлэг татварын бус орлого	278,951,262.11	323,157,088.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	278,951,262.11	323,157,088.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	278,951,262.11	323,157,088.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,198,411,200.00	1,096,405,600.00
Улсын төвлөрсөн төсвөөс	1,112,982,100.00	995,528,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,112,982,100.00	995,528,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,429,100.00	100,877,600.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,429,100.00	100,877,600.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,352,936,146.31	1,601,553,048.00
УРСГАЛ ЗАРДАЛ	1,352,936,146.31	1,601,553,048.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,289,904,594.59	1,570,445,962.94
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	907,704,890.50	1,179,709,263.71
Үндсэн цалин	521,021,317.67	713,699,390.13
Нэмэгдэл	360,120,517.00	375,553,112.34
Унаа хоолны хөнгөлөлт	-	29,299,186.00
Урамшуулал	26,563,055.83	61,157,575.24
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,652,236.81	138,121,580.29
Тэтгэврийн даатгал	77,813,497.27	93,085,022.89
Тэтгэмжийн даатгал	9,469,181.68	11,487,668.75
ҮОМШӨ-ний даатгал	4,109,037.90	5,557,788.97
Ажилгүйдлийн даатгал	4,020,732.94	5,529,638.94
Эрүүл мэндийн даатгал	18,239,787.02	22,461,460.74
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,902,757.28	67,033,828.94
Гэрэл, цахилгаан	18,366,816.16	19,205,784.98
Түлш, халаалт	29,997,281.12	39,944,643.96
Цэвэр, бохир ус	11,538,660.00	7,883,400.00
Хангамж, бараа материалын зардал	100,000.00	-
Бичиг хэрэг	100,000.00	-
Нормативт зардал	135,066,310.00	134,492,610.00

Хоол, хүнс	135,066,310.00	134,492,610.00
Эд хогшил, урсгал засварын зардал	14,600,000.00	11,000,000.00
Урсгал засвар	14,600,000.00	11,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,741,300.00	3,792,230.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,741,300.00	3,792,230.00
Бараа үйлчилгээний бусад зардал	56,137,100.00	36,296,450.00
Бараа үйлчилгээний бусад зардал	43,522,800.00	28,229,850.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,614,300.00	8,066,600.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,031,551.72	31,107,085.06
Бусад урсгал шилжүүлэг	52,105,209.00	8,263,314.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	52,105,209.00	8,263,314.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,926,342.72	22,843,771.06
Төвлөрүүлэх шилжүүлэг	10,926,342.72	22,843,771.06
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>124,426,315.80</u>	<u>(181,990,360.00)</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,004,900.00	4,201,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,004,900.00	4,201,000.00
Дотоод эх үүсвэрээр	20,004,900.00	4,201,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,004,900.00	4,201,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(20,004,900.00)</u>	<u>(4,201,000.00)</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	104,421,415.80	(186,191,360.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	223,602,764.24
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	223,602,764.24	37,411,404.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	/Төгрөгөөр/
			Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,575,000.00	2,220,189,400.25	2,354,764,400.25
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	134,575,000.00	2,220,189,400.25	2,354,764,400.25
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	134,575,000.00	2,220,189,400.25	2,354,764,400.25
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	(244,399,643.84)	(244,399,643.84)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,575,000.00	1,975,789,756.41	2,110,364,756.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,709,595,900.00	1,578,709,276.94
УРСГАЛ ЗАРДАЛ	1,709,595,900.00	1,578,709,276.94
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,701,332,400.00	1,570,445,962.94
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,223,921,700.00	1,179,709,263.71
Үндсэн цалин	787,390,500.00	713,699,390.13
Нэмэгдэл	395,336,500.00	375,553,112.34
Унаа хоолны хөнгөлөлт	-	29,299,186.00
Урамшуулал	41,194,700.00	61,157,575.24
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,582,300.00	138,121,580.29
Тэтгэврийн даатгал	102,831,800.00	93,085,022.89
Тэтгэмжийн даатгал	12,187,700.00	11,487,668.75
ҮОМШӨ-ний даатгал	6,093,700.00	5,557,788.97
Ажилгүйдлийн даатгал	6,093,700.00	5,529,638.94
Эрүүл мэндийн даатгал	24,375,400.00	22,461,460.74
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,877,600.00	67,033,828.94
Гэрэл, цахилгаан	24,118,400.00	19,205,784.98
Түлш, халаалт	51,430,100.00	39,944,643.96
Цэвэр, бохир ус	14,329,100.00	7,883,400.00
Нормативт зардал	176,722,400.00	134,492,610.00
Хоол, хүнс	176,722,400.00	134,492,610.00
Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	11,000,000.00
Урсгал засвар	11,000,000.00	11,000,000.00

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,040,400.00	3,792,230.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,040,400.00	3,792,230.00
Бараа үйлчилгээний бусад зардал	43,188,000.00	36,296,450.00
Бараа үйлчилгээний бусад зардал	32,632,900.00	28,229,850.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,555,100.00	8,066,600.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,263,500.00	8,263,314.00
Бусад урсгал шилжүүлэг	8,263,500.00	8,263,314.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,263,500.00	8,263,314.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,709,595,900.00	1,419,562,688.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,003,661,300.00	995,528,000.00
Улсын төсвөөс санхүүжих	1,003,661,300.00	995,528,000.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	100,877,600.00	100,877,600.00
Орон нутгийн төсвөөс	100,877,600.00	100,877,600.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,057,000.00	323,157,088.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	396,901,000.00	323,157,088.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	208,156,000.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	223,602,764.24
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	37,411,404.24

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 347,664.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 347,664.2 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнтэй тулгахад 286,237,712.0 төгрөгийн зөрүүтэй тусгасан байна. Энэ нь УСНББОУС 1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.
- Зардлын дансанд нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд хангамж, бараа материалын зардлыг 27,172,779.0, норматив зардлыг 5,674,472.0, эд хогшил, урсгал засварын зардлыг 750,000.0, бараа үйлчилгээний бусад зардлыг 27,829,207.0 төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар нийт 854,256.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,535.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 852,720.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнтэй тулгахад 286,237.7 мянган төгрөгийн зөрүүтэй тусгасан байна.	1	286,237.7			1	286,237.7	1	286,237.7				
Зардлын дансанд нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд хангамж, бараа материалын зардлыг 27,172.8, норматив зардлыг 5,674.5, эд хогшил, урсгал засварын зардлыг 750.0, бараа үйлчилгээний бусад зардлыг 27,829.2 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэсэн байна.	1	61,426.4			1	61,426.4	1	61,426.4				
Дүн	2	347,664.1			2	347,664.1	2	347,664.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томилолтын зардлыг тулган баталгаажуулахад 450.0 мянган төгрөгийн томилолтын зардал анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.	1	450.0	1	450.0								
Хүүхдийн хоолны зардлыг тулган баталгаажуулахад 1,085.9 мянган төгрөгийн норм хэтрүүлэн зарцуулсан байна.	1	1,085.9	1	1,085.9								
Бараа материалын тайланг тулган баталгаажуулахад хүнсний тайлангийн 70,384.6 мянган төгрөгийн 5 ширхэг орлогын баримт, 20,542.6 мянган төгрөгийн 1 ширхэг зарлагын баримт тус тус дутуу байна.	1	90,927.2			1	90,927.2						
Тайлант онд байгууллагын албан хаагчдад 90,333.1 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо "Нэмэгдэл	1	90,333.1			1	90,333.1						

хөлс тооцож олгох хуудас"-ыг бүрэн хөтлөөгүй, байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй олгосон байна.												
Дүн	4	182,796.2	2	1,535.9	2	181,260.3						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 18,412.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 22,843.8 мянган төгрөгийн 1 гүйлгээ мэдээлээгүй, 397,315.0 мянган төгрөгийн орлогын 19 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 232,889.7 мянган төгрөгийн орлогын 10 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	671,460.6			1	671,460.6		
Дүн	1	671,460.6			1	671,460.6		